

**ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
БУСАД ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭНД ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын бусад ажиллагаанд оролцох төрлийг нэмэгдүүлэх, энхийг дэмжих ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 35-д “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулах, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны 02 дугаар зөвлөмжийн 2.1-д “Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас цагдаагийн баг оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж заасныг үндэслэн Засгийн газраас Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдыг ямар журмаар сонгон шалгаруулж авдаг, уг үйл ажиллагаанд оролцсоноор манай улсад болон тухайн цэргийн алба хаагчдын олох орлого болон зарлагын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хуулийн төслийн 4.4-т тухайн цэргийн алба хаагчийг энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаанд өөр албан тушаалд өөртэй нь тохиролцсоны дагуу томилж, эргэж ирэхэд нь ямар албан тушаалд томилж ажиллуулах талаар, цэрэг, цагдаагийн алба хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэх тухай зохицуулалт өмнөх хуульд байсан эсэх, энэ тохиолдолд заавал цэргийн албанаас чөлөөлөх эсвэл энгийн алба хаагч нараас сонгон шалгаруулах эсэхийг тодруулаад, төслийн 7.1.6-д “Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон нөхөн төлбөрөөс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал болон Зэвсэгт хүчний болон Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох;” гэж заасан нь цаашид өөрчлөгдөх эсэх, цагдаагийн алба хаагчид нэгдсэн цэргийн командлалын удирдлагад хамрагдах эсэх талаар тодруулан асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан энхийг сахиулах ажиллагаанд онцгой байдлын алба хаагчдыг оролцуулах боломжтой эсэх, тэднийг уг ажиллагаанд оролцуулснаар дэлхий нийтэд тохиолдож буй гамшгийн болон хохирлын голомтод ажиллаж туршлагажих, бэлтгэгдэх хэрэгцээ, шаардлага байгаа болохыг онцлоод, цагдаагийн алба хаагчид энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсоноор ямар давуу талыг өөрсөддөө бий болгох, тухайн алба хаагчид ямар үйл ажиллагааны хүрээнд ажиллах тухай болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн рот, хохирлын дараах сэргээн босголтод батлан хамгаалах салбарын инженерийн ротыг оролцуулах эсэх талаар баримталж буй бодлогын тухай тодруулан асууж, хариулт авсан болно.

Хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

ТУС3761 9023051390 9087184